



### Суурьтай гуулин арслан.

XIX зууны сүүл, XX зууны эхэн үеийн Хүрээний урчуудын бүтээл. Монголчууд тамганы савыг сүр хүчийг бэлэгдсэн арслангийн дүрсээр дөрвөн талт хэлбэртэй хийдэг байсныг гэрчлэх тус арслангийн дүрст савны гэрийг зэс, гуулиар цутгаж хийсэн бөгөөд арслангийн оойж суусан дүр төрх, түүний зүүн урд талын хөлд буй бамбар, хүзүүний унжлага бүхий цацаг чимэглэл зэргийг маш нарийн гаргаж өгснөөрөө онцлог. бүхий зууны арсланг дүрсэлдэг гаргадаг ерөнхий зураглалын дагуу бүтээгджээ.



**Улаанбаатар хотын анхны дарга Моононгийн Баярын хэрэглэж байсан бичгийн машин.** 1920-иод оны үед уйгаржин монгол үсэг бүхий бичгийн машиныг АНУ-д захиалан хийлгүүлжээ.

### Улаанбаатар хотын музей байрлаж буй байшингийн түүх

XX зууны эхэн үед Нийслэл хүрээнд Оросын Буриад худалдаачид худалдаа, сууцны зориулалтаар олон байшин барьсны нэг нь 1918-1919 онд баригдсан Цогт Гармаевич Бадамжавын байшин юм. Тухайн үеийн Нийслэл хүрээний чамин тансаг байшингуудын нэг болж байсан тус байшинг Цогтбадамжав өөрийн хувийн сууцны зориулалтаар барьжээ. Цогтбадамжав байшингаа хийц, загварын хувьд чамин өвөрмөц төрхтэйгөөр хийснээс гадна байшингийнхаа орой дээр Оросын хаан ширээ нуран унасныг бэлгэдэж дөрвөн хөлийг дээш харуулсан ширээ байрлуулсан нь түүнийг хувьсгалт дэвшилт үзэлтэй хүн байсныг харуулдаг.



Цогт Гармаевич Бадамжав нь 1899-1930 онд Монгол-Түвдийг судлах Козловийн экспедицийн орчуулагчаар ажиллахын зэрэгцээ Орос, Монголын хооронд худалдаа хийдэг Хиагт пүүс болон Хятад, Англи, Герман пүүсүүдэд брокероор ажиллаж байжээ.

Тэрээр Д.Сүхбаатар тэргүүтэй ардын журамт цэргүүд 1921 оны 7-р сарын 8-ны өдөр Нийслэл Хүрээг чөлөөлөх үед энэхүү байшингийнхаа нэгэн өрөөг жанжин Д.Сүхбаатарт хүлээлгэн өгсөн байна. Тус байшинд 1921 оны долдугаар сард Монгол Ардын Намын төв хороо, Ардын Түр Засгийн Газар, Бүх цэргийн штаб байрлаж, жанжин Д.Сүхбаатар ажиллаж байжээ. 1930-аад оны үед тус байшинд Зөвлөлт-Тува улсын элчин сайдын яам байрлаж байв. 1944 онд МАХН-ын Төв хорооны 7-р тогтоолоор уг байшинд Д.Сүхбаатарын музей байгуулах шийдвэр гарч 1946 оны 3-р сарын 1-нд МАХН-ын 25 жилийн ойг тохиолдуулан Д.Сүхбаатарын музейг байгуулжээ. 1953 онд Д.Сүхбаатарын музейг Х.Чойбалсангийн музейтэй нэгтгэж Сүхбаатар-Чойбалсангийн ордон музей болгон нэгтгэхэд эндээс музейн бүх зүйлс тэр музейд шилжиж, энэ байшинд Хэвлэлийн төв газар оржээ.


Тус байшингийн байрлаж байгаа газрыг түүхэн талаас нь авч үзвэл, Сэцэн хан аймгийн суурин жасааны дэнжийн баруун өмнөдөд байсан “Манж амбаны хороо”, Олноо өргөгдсөний үед Сангийн яамны байгууллагууд байрлаж эхэлсэнээс хойш “Сангийн яамны хороо” гэж нэрлэгдэж байсан эл хороонд XX зууны эхэн үед Цогтбадамжав, Юмтаровь нарын баячууд амьдардаг байжээ.

Цогтбадамжавын байшинг Сайд нарын зөвлөлийн 1971 оны 420-р тогтоолоор “түүх, соёлын үл хөдлөх дурсгалт байшин” гэж үзээдүлсын 2-р зэргийн хамгаалалтанд, Монгол Улсын Засгийн газрын 1994 оны 233-р тогтоолоор “Хотын хамгаалалтанд байх түүх, соёлын дурсгал”-д, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 175-р тогтоолоор “Улсын хамгаалалтанд байх, түүх соёлын дурсгал”-д бүртгэн авсан.

#### Харилцах хаяг:

Баянзүрх дүүрэг, 15-р хороо, Энхтайвны өргөн чөлөөний 37, Улаанбаатар хотын музей  
Улаанбаатар 13370

Утас: 450960; [www.ubmuseum.mn](http://www.ubmuseum.mn)  
[facebook.com/HelloUlaanbaatar](https://facebook.com/HelloUlaanbaatar)  
(Сайн байна уу Улаанбаатар минь)



# УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ



## УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙН ТОВЧ ТҮҮХ

Эх орны маань нэрийн хуудас-нийслэл Улаанбаатар хотын түүхэн замнал, хөгжил дэвшлийг нийслэлийн иргэд, зочид гийчдэд таниулах зорилгоор 1956 онд “Улаанбаатар хотын түүхийн үзэсгэлэн” нэртэйгээр анх байгуулагдсан.

МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны 1960 оны 106-р тогтоолоор “Улаанбаатар хотын түүхийн үзэсгэлэн”-г “Улаанбаатар хотын түүх, шинэчлэн байгуулалтын музей” болгон өргөтгөхөд түүхч Х.Пэрлээ, зураач Ү.Ядамсүрэн нар идэвхитэй оролцож, зураач Ү.Ядамсүрэн үзмэр зохион байгуулах эскизийг хийж, түүхч Х.Пэрлээ үзмэр дэглэлтийг зохион байгуулж хийсэн байна. Музейг шинээр байгуулахтай холбогдож 1960 онд СнЗ-ийн тогтоолоор музейн орон тоо, цалинг нэмж тайлбарлагч 2, фото зурагчин 1, манаач 2-ийг нэмж батлан нийт 12.5 орон тоотойгоор ажиллуулж эхэлжээ.

Тус музей байгуулагдсан цагаас хойш “Улаанбаатар хотын түүхийн үзэсгэлэн”-гийн даргаар Рагчаасүрэн, 1960 оноос “Улаанбаатар хотын Түүх, Шинэчлэн байгуулалтын музей”-н даргаар Лувсанцэрэн, 1962 оноос Н.Дүрзээ, 1977 оноос Цагаач, 1987 оноос музейн захирлаар М.Мижидгомбо, 1992 оноос Б.Бизъяа, 2005 оноос Б.Болдбаатар, 2011 оноос Улаанбаатар хотын музейн захирлаар С.Цацралт ажиллаж байна.

Тус музей нь Улаанбаатар хотын түүхийг үзүүлэгээр дэглэн үзүүлэхдээ Нүүдлийн Өргөө, Их хүрээ(1639-1778 он), Их хүрээ хот (1778-1911 он), Нийслэл хүрээ (1911-1924 он), Улаанбаатар хот (1924-1990 он), (1990 оноос хойш) хэмээн хуваан үзэж, үзүүлэгийн гурван танхимаар үзмэрээ дэлгэн үзүүлдэг.

Музейн сан хөмрөг 3300 гаруй үзмэртэйгээс үзүүлэгийн танхимд нийт үзмэрийн тавны нэг нь тавигдаж үзэгчдийн хүртээл болж байна. Музейн сан хөмрөг дэх үзмэрийн онцлох заримаас сонирхуулвал, Туул голын хөндийгөөс олдсон 5 сая жилийн тэртээ амьдарч байсан Арслан зааны яс, XIX-XX зууны үед Их хүрээний урчууд урласан өвөрмөц хийц, загвар бүхий ахуйн гоёл чимэглэлүүд, нэрт зураач Манибадар 1946 онд зурсан “Нийслэл хүрээ” зураг, Төрийн соёрхолт, гавъяат сийлбэрчин Д.Сэнгээгийн “Түүхт Улаанбаатар” зааны соён сийлбэр, уран хатгамалч А.Цэрэнхүүгийн “Л.И.Брежнев” торгон утсан хатгамал, 1976-2000 он хүртэл Улаанбаатар хотыг хөгжүүлэх III ерөнхий төлөвлөгөө зэргийг энд дурдаж болно.



**Нийслэл хүрээ.** Уран зураг. 1915 онд Богдын ордны зураач Жүгдэр зурсныг 1946 онд зураач Д.Манибадар томруулан хуулбарлаж зурсан. Тус зураг Улаанбаатар хотын музейн сан хөмрөгт хадгалагдаж байна. Жүгдэрийн “Нийслэл хүрээ” зураг нь XX зууны эхэн үеийн нийслэл хүрээний хүн амын нягтшил, албан яам, тамгын газрууд, тэдгээрийн ялгааг тодорхойлон харуулснаас гадна Нийслэл хүрээ хавийн сүм хийдүүдийг багтааж, түүнчлэн хаад, ноёд, хутагт хувилгаадын зэрэг дэвийн ялгаа, албан газруудын эрх хэмжээний байдал, хотын оршин суугчдын төрх зэргийг нарийн тодорхойлсноороо уран зургийн дурсгал төдийгүй түүх, зурагзүйн чухал дурсгал юм.



**“Түүхт Улаанбаатар”** зааны соён сийлбэр: БНМАУ-ын нийслэл Улаанбаатар хотын 50 жилийн ойд зориулж 1974 онд уран сийлбэрч С.Сэнгээ бүтээсэн. Улаанбаатар хот дахь түүх, соёлын дурсгал, барилга байгууламжаар төлөөлүүлэн хотын хөгжил дэвшлийг харуулахыг зорьсон ба бүтээлийн уран нарийн хийц, загвар зохиомж, ашигласан материал зэрэг нь өвөрмөц, онцлог бүхий хосгүй үнэт бүтээл юм. Зааны соёоны урт 162 метр, өргөн нь 11 см.



**Янтай** Улаанбаатар хотын музейн сан хөмрөгт хадгалагдаж буй Янтай, цоож нь XX зууны эхэн үеийн Хүрээний уран дархчуудын урласан сор бүтээлийн нэг юм. Янтай нь бичиг, номын хүмүүсийн хэрэглэдэг байсан бэх хийх зориулалт бүхий сав юм. Янтайн дээд хэсгийг арван хоёр жилийн амьтнаар хүрээлж, түүний дотор талд дөрвөн хүчтэн, эвтэй дөрвөн амьтныг сийлж шармалдан, савны хоёр хажуу талыг цэцгэн хээ угалзаар чимэглэн өнгө зохилдлого, хийц загварыг нарийн гаргаж өгчээ. Цоож нь эх бие, өргөс, түлхүүрээс бүрдэх бөгөөд хэмжээний хувьд 1.9x1.7 см, 10 гр жинтэй. Нүүрэн хэсэгт товойлгон гаргаж шармалдсан арслангийн дүрстэй. Энэхүү цоож нь монголын музейнүүдэд хадгалагдаж байгаа хамгийн жижиг цоож юм.



Л.И.Брежневийн хатгамал: 1981 онд Зөвлөлтийн удирдагч Л.И.Брежнев (1906-1982)-ийг БНМАУ-ын “Хөдөлмөрийн баатар” цолоор шагнахад түүнд зориулан уран хатгамалч А.Цэрэнхүү 1982 онд тус торгон утсан хатгамлыг бүтээжээ. Энэхүү бүтээлийг уран нарийн оёж, уран зураг шиг дүрслэлийн ялгарлыг нарийн гаргасан нь монголын орчин үеийн уран хатгамлын урлагт тодоор дуурсагдах гайхамшигт нэгэн бүтээл болсон юм.